



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

2024 ОНЫ 09 ДҮГЭЭР
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

СӨҮЛ ХОТ

2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСАГ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.1 Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 35 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг 09 дүгээр сарын 05-ны өдөр танхимаар зохион байгуулж 28 гэрээт иргэнийг хамруулан дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгсөн. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
- Солонгос Улсын хууль, дүрэм, журам
- Монгол иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Үйлдвэрлэлийн осол, үйлдвэрлэлийн ослын даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэх мэт.

1.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 09 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлыг шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **246** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, гэнэтийн ослын даатгал, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэг хэлбэрээр нийт **129,505,214.00** воныг Монгол Улсын **28** иргэнд олгуулсан.

Хүснэгт 1: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан мөнгөн дүнгийн жагсаалт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн сар тутмын тоон мэдээ

/2024 оны 08 дугаар сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	129,505,214 /28 иргэнд/
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	246

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад үйлдвэрлэлийн ослоор гэмтэл авсан Б.С-ийн хэвтэн эмчлүүлж байгаа эмнэлэг дээр очиж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.

Хууль бусаар ажиллаж амьдарч байгаад уушгины хүнд хэлбэрийн үрэвслийн улмаас нас барсан иргэн М.Ө-ын Самсунг даатгалын 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал 3,755,440.00 воныг ээж Ч.Н-н дансанд шилжүүлж, олгуулсан.

1.1.3 Төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор БНСУ-ын Дэгү хотод оршин сууж буй Монгол Улсын иргэдэд 2024 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр явуулын үйлчилгээг зохион байгуулж, тус арга хэмжээнд хүрэлцэн ирсэн 40 гаруй иргэнд хөдөлмөр, нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг таниулан, хөдөлмөрийн харилцаа, сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийг өгч мөн төвийн танилцуулга, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагыг тараасан.

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Шихын хотод зохион байгуулагдсан хөдөлмөрийн гэрээт ажилчдын спорт урлагийн нэгдсэн фестивалийн үеэр явуулын үйлчилгээ үзүүлж, 100 гаруй иргэнд төвийн танилцуулга, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гарын авлага тараасан. Мөн холбогдох газруудад хүсэлт илгээн шагналын цом 500,000.00 воноор ивээн тэтгүүлж, тус арга хэмжээнд тэргүүн байр эзэлсэн гэрээт иргэдэд гардуулж өгсөн.

2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Шиндорим дахь христийн сүмд зохион байгуулсан арга хэмжээний үеэр байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гэрээт ажилчдыг ур чадвартай ажиллах хүчний визний ангилал руу шилжүүлэх ажлын хүрээнд:

1.2.1 E-7-4 визний асуудлаар нийт 18 иргэнтэй утас, цахимаар холбогдож оноо цуглуулах, гэр бүлийн гишүүдийг урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, бүртгэлийн санг баяжуулсан.

3. БНСУ-д оршин сууж байгаа монгол гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ, дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлын хүрээнд:

1.3.1 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Сөүл хотын олон соёлт гэр бүлийн хэлтсийн Гадаад иргэдийн тасгийн дарга И Юн Бом болон бусад мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцсон.

1.3.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тусалцаа үзүүлэх чиглэлээр, ганцаарчилсан сэтгэл засал нийт 22 хүнд, нойргүйдэл, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилт илрүүлэх сорилыг 10 хүнд, өнгөний сорилыг 10 удаа тус тус хийлгэж, үнэлэлт дүгнэлт хийсэн. Мөн байгууллагын ажилчдын харилцаа хандлагыг дээшлүүлэх, ажлын байрны стрессээс сэргийлэх зорилгоор 14 ажилтанд картын арга ашиглан бүлгийн сэтгэл засал хийсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.1 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 16 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 16, гэрээний хугацаа сунгасан 7, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 6, нийт 29 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгосон.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.2.1 Нийт 46 иргэнийг сайн дурын нийгмийн даатгалд шинээр хамруулж, БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 24 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгосон.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах ажлын хүрээнд:

2.3.1 НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө

416,483,250.00 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 60 хувиар биелүүлсэн бөгөөд хүснэгт 2-оор харуулбал:

Хүснэгт 2: Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт 09 сарын 30-ны өдрийн байдлаар

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг		
9	416,483,250.00	44,764,000.00	113,252,920.00	137,263,649.00	44,764,000.00	250,516,569.00	60	2.53

2.3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын 465 ширхэг шимтгэл төлөх нэхэмжлэл факсаар илгээн, нийт 555 даатгуулагчтай шимтгэл төлөхийг сануулж, утсаар холбогдсон.

2.3.3 Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 09 дүгээр сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

4. Тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчдад баримт олгох ажлын хүрээнд:

2.4 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 2 даатгуулагчид шаардлагатай бичиг баримтыг Монгол хэлнээ хөрвүүлж, зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

5. Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, тэдний хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:

2.5 Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 273, үүнээс 200 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 73 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажилласан. Мөн БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг 09 дүгээр сарын 05-ны өдөр танхимаар зохион байгуулж 28 гэрээт иргэнийг хамруулан Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгуулж, сурталчилгааны материал тарааж ажилласан.

6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлийн буцаан олголтыг олгуулах ажлын хүрээнд:

2.6 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлж УТА-д илгээсэн 207, 208 дугаар ээлжийн иргэдийн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ажлын хүрээнд:

3.1.1 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын “БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгтгэн 2024 оны 3/201 тоот албан бичгийг тус яамны холбогдох албан тушаалтанд цахим шуудангаар хүргүүлсэн.

3.1.2 2024 оны 09 дүгээр сарын 10-нд "Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй зохион байгуулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд гарч буй нийтлэг зөрчил, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хүнд суртал, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар цогц мэдээлэл өгөх" сургалтыг Авлигатай тэмцэх газраас цахимаар зохион байгуулж, нийт 18 ажилтан хамрагдсан.

3.1.3 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр МҮЭХ болон БНСУ-ын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоодтой хамтын ажиллагааны уулзалтыг зохион байгуулж, цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллахаар болсон.

3.1.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд 2024 оны 1-8 дугаар сард ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн, ГБХНХЯ-нд цахим шуудангаар хүргүүлсэн.

3.1.5 Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 11 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг холбогдох программаас илгээсэн. Мөн нийгмийн даатгалын лавлагаа авах хүсэлт гаргасан 7 иргэний хүсэлтийн дагуу мэдээллийг холбогдох программаас шүүж, хүлээлгэн өгсөн.

3.1.6 Удирдлагын академиас зохион байгуулсан "Төрийн албаны шинэчлэл: шинэ 30 жил" сургалт, Төрийн албанаас зохион байгуулсан 7:4:10 "Төрийн албан хаагчдад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр" сургалтад тасгийн албан хаагчид тус тус хамрагдсан.